

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

ОУДС-ийн нийт хамт олон та бүхний амрыг эрж мэндчилье!

Намайг Улаанбаатарт болон ОУДС-д халуун дотноор хүлээж авсан та бүхэнд баярлалаа. Манай эхнэр Ivonne бид хоёр Монголд ирсэндээ их баяртай байна. Бид Гонконгоос 7 сарын 30-нд Pfofen, Phoebe нэртэй 2 нохойны хамт ирсэн бөгөөд гэр орноо тохинуулж орчин тойронтойгоо танилцаж нэлээд завгүй байлаа.

Ирсэнээсээ хойш сургуулийн хамт олонтойгоо 8 сарын 22-ны хичээлийн шинэ жилийн нээлтийн ажиллагаанд бэлтгэх ажил миний эн тэргүүний зорилт байлаа. Бид 2011-2012 оны хичээлийн шинэ жилийн нээлтээ Даваа гарагт хийсэн. Ирэх хичээлийн жилийн нээлтийн ёслолд Монгол уламжлалын арга хэмжээ оруулах хүсэлтэй байгаа тул та бүхэн санал хүсэлтээ director@isumongolia.edu.mn хаягаар надад ирүүлээрэй.

Ирэх 8 долоо хоногийн турш би ОУДС-ийн дотоод ажилтай илүү нарийвчлан танилцах төлөвлөгөөтэй байгаа. Энэ хугацаанд би багш ажилтнууд, сурагчид, эцэг эхчүүд, Удирдах Зөвлөлийн гишүүдтэй уулзаж зөвлөлдөн сургуулийн үйл ажиллагааг өргөн хүрээнд ажиглах шаардлагатай байна. Аль болох богино хугацаанд шинээр ажиллахаар ирсэн сургуулийнхаа үйл ажиллагааг сайтар нягтлан мэдэж авах нь миний гол зорилт байх болно. Үүний дараагаар өөрийн олж мэдсэн зүйлсийн талаар тайлан бичиж ОУДС-ийн захирлын хувьд эхний жилд ямар ажлыг эн тэргүүнд хийх талаар төлөвлөгөө гаргах болно.

Тайлангаа хийж дуусаад би Удирдах Зөвлөлийн гишүүд болон багш ажилтнууд, сургуулийн нийт хамт олонтой энэ тайлангийнхаа талаар хуваалцах болно.

Өнгөрсөн тавдугаар сард ОУДС-д зочилж ирэхдээ сургуультайгаа танилцах боломж надад олдсон юм. Улаанбаатарын эдийн засгийн хөгжилд ахиц гарч гадаад мэргэжилтнүүдийн тоо өсч байгаатай холбогдуулан ОУДС-ийн хамт олон сургуулиа стратеги төлөвлөгөөтэйгээр хөгжүүлэхийн төлөө ажиллаж байгаа нь надад гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн. Стратеги төлөвлөгөөний зургаан үндсэн зорилтууд сургуулийн эрхэм зорилго, үнэт зүйлстэй нягт уялдаатай байгаа нь хамгийн чухал юм. Олон улсын боловсролын талаарх миний хувийн үзэл бодолтой энэхүү цогц бодлого нь нийцэж байсан явдал нь намайг ОУДС-д ирж ажиллах миний шийдвэрт нөлөөлсөн.

Ойрын хугацаанд би та бүхэнтэй уулзаж ОУДС-ийг бид хэрхэн улам шилдэг сайн сургууль болгох вэ гэдэг талаар ярилцах болно.

Захирал Robert Stearns

ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:

8 сарын 30-ны Мягмар гараг

Эцэг Эх Багш нарын Бүлгийн Хурал
8:20-9:00 сургуулийн кафетерияд-эцэг эхчүүд
та бүхнийг урьж байна

8 сарын 31-9 сарын 2

Дунд Сургуулийн Кэмп Аялал-Тэрэлж,
Бүүвэйт, Хустай

9 сарын 2-ны Баасан гараг	Бага Сургуулийн Пикник, Өдрийн хоолыг сургуулиас хангана
9 сарын 6-ны Мягмар гараг	Дугуйлангууд хичээллэж эхэлнэ
9 сарын 8-ны Пүрэв гараг	Нээлттэй Хаалганы Өдөрлөг 18:30-20:30 ЗӨВХӨН ЭЦЭГ ЭХЧҮҮД ОРОЛЦОНО
9 сарын 13-ны Мягмар гараг	12-р ангийн сурагчдын эцэг эхэд коллежийн мэдээлэл өгөх уулзалт- 18:30-20:00 Номын Санд
9 сарын 15-ны Пүрэв гараг	Монгол, Солонгос эцэг эхчүүдэд ОУДС-ийн талаар мэдээлэл өгөх уулзалт 18:30
9 сарын 17-ны Бямба гараг	ОУДС-ийн Намрын Баяр 11:00-14:00
9 сарын 23-ны Баасан гараг	Фото Зургийн өдөр

Нээлттэй Хаалганы Өдөрлөг

Нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр эцэг эхчүүд та бүхэн хүүхдийнхээ багш нартай уулзаж хичээлийн хөтөлбөр болон **IV** байгууллагын гурван хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой. Манай Нээлттэй хаалганы өдөрлөг 9 сарын 8-ны Пүрэв гарагт 18:30-20:30 цагт сургууль дээр болно. Энэ өдрийг та бүхэн хуанлидаа тэмдэглээрэй.

Захидал, мэдээллүүд-Баасан гарагт та бүхэнд очиж байх болно. Сургууль гэр бүлийн хоорондын харилцааг сайжруулах үүднээс бид долоо хоног бүрийн Баасан гарагт та бүхэнд хамааралтай мэдээ, мэдээлэл, бөглөх хуудас, захидлуудыг хэвлэн сурагчдаар гэрт нь явуулж байх болно. Сургуулийн Мэдээг е-мэйлээр бид Баасан гараг бүрт та бүхэнд илгээдэг. Энэ өдөр та бүхэн сургуулиас явуулсан захидал, бөглөх хуудас, мэдээллийг хүлээн авч байх болно.

Эрхэм Хүндэт Эцэг Эхчүүд, Сурагчид та бүхэн сургуулийн үүдний талбайд ургасан мод, бут, өнгө алагласан цэцэгсийг ажигласан байх аа. Өнгөрсөн жил манай **Roots & Shoots** дугуйлангийн сурагчид төрөл бүрийн олон арга хэмжээ зохиож хуримтлуулсан хөрөнгөөрөө мод, бут худалдан авч сургуулийн орчныг цэцэрлэгжүүлэх ажлыг хийсэн. Та бүхэн манай сурагчдын санаачлагыг дэмжиж ажилласанд баярлалаа.

Энэ жил бид **Roots&Shoots** дугуйлангаа Мягмар гараг бүрт үргэлжлүүлэн явуулах бөгөөд сурагчид маань хэд хэдэн төсөл хэрэгжүүлэх бодолтой байгаа. Хэрвээ та бүхэнд бидний тусламж хэрэгтэй бол бид та бүхэнтэй дахин хамтран ажиллахад бэлэн байна.

Багш Margriet Faber

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Сурагчид та бүхэнтэй хичээлийн шинэ жилд дахин уулзсандаа баяртай байна. Та бүхэн миний нэгэн адил зуны амралтаа сайхан өнгөрүүлсэн гэдэгт би итгэлтэй байна.

Та бүхэн шинэ захирал Bob Stearns, Бага Сургуулийн Эрхлэгч Rick Elya нартай танилцсан гэдэгт би итгэлтэй байна. Эдгээр хүмүүс манай сургуульд ирж бидэнтэй хамтран ажиллаж байгаад би баяртай байна.

Ирэх долоо хоногийн Лхагва, Пүрэв, Баасан гарагуудад дунд сургуулийн сурагчид Кемп аялалдаа явна. 6-8-р ангийн сурагчид Тэрэлжийн орчим Тэнгэрийн Элч Кемпэд; 9,10-р ангийн сурагчид Бүүвэйгэд; 11,12-р ангийн сурагчид Хустайн Нуруунд аялалаа хийнэ. Та бүхэн сурагчдад хээрийн аялалд тохирсон хувцас бэлтгэж авч явахад нь туслаарай. Жил бүр манай аялал сонирхолтой болж багш сурагчид хоорондоо танилцдаг уламжлалтай. Монгол орны цаг агаар эрс тэс уур амьсгалтай учир та бүхэн аялалдаа сайн бэлтгэж дулаан, аюулгүй, чийг нэвтэрдэггүй хувцастай явахыг бид хүсэж байна.

Манай сургуулийн төгсөх ангийн сурагч Neil Rutherford EARCOS байгууллагын Global Citizen Community Service Grant шагнал хүртэж 500 ам доллараар шагнагдсан. Neil-д баяр хүргэж Кампучид хэрэгжүүлэх төсөлд нь амжилт хүсэн ерөөе!

Зун дуусах дөхөж байгаа энэ үед та бүхэн амралтаа сайхан өнгөрүүлээрэй.

Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

ОУДС-д ирж ажиллах болсондоо мөн энэ долоо хоногт та бүхэнтэй уулзсандаа би баяртай байна. IB байгууллагын бодлого, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж буй ОУДС-ийн хамт олон та бүхний ололт амжилт энэ сургуульд ирж ажиллах миний сонголтонд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн.

Би АНУ-ын Сиаттл хотоос ирсэн. Энд би бага сургуулийн 1-5-р ангид хичээл заадаг байсан. 11 жилийн өмнөөс би олон улсын сургуулиудад ажиллаж эхэлсэн бөгөөд Японы Осака, Хятадын Гуанжоу мужийн олон улсын сургуульд ажиллаж байсан.

Сурагчдад сургалтын аюулгүй, таатай орчинг бүрдүүлж, тэднийг бие даан суралцаж аливаа сорилтыг даван туулах чадвартай болгож төлөвшүүлэх нь миний гол үндсэн зорилго байх болно.

Би та бүхэнтэй бүгдтэй нь ойрын хугацаанд уулзана гэж найдаж байна.

Бага Сургуулийн Эрхлэгч Rick Elya

Бага Сургуулийн Пикник

Бага сургуулийн сурагчдын пикник өдөрлөг 9 сарын 2-ны Баасан гарагт болно. Пикник нь бага сургуулийн хамт олныг нэгэн хүчирхэг баг болж дотно танилцаж нөхөрлөх боломж олгодог юм. Бэлтгэл ангиас 4-р ангийн сурагчид хэсэг хэсгээрээ нэг бүлэг болж хуваагдан олон төрлийн тоглоом ээлжлэн тоглох болно. 5-р ангийн сурагчид тоглоомын үйл ажиллагааг багш нарын хамт хариуцаж явуулах болно. Сурагчдын өдрийн хоолыг сургуулиас хангана.